



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn


2024. 07. 30, № 397
танай _____-ны № _____ т

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
ГҮЙЦЭТГЭЛ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

“Сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэл” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлан, судалгааг хүргүүлж байна.

Хавсралт 9 хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР  Д. БАТ-УНДРАА





ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

УИХ-ын ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт гаргах

Сонгуулийн зардлын төсвийн төсөлд орон нутгийн байгууллагуудаас санал авалгүй дээд шатны байгууллагаас шууд хуваарилсан байна

АУДИТЫН КОД: ЗАА-2024/06-ШТА-НА

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа



Улиастай
2023 он

Утас: 7046-3612, цахим хаяг: bat-undraad@audit.gov.mn
Аудитын менежер Х.Болдбаатар
Утас: 7046-3783, цахим хаяг: boldbaatar.kh@audit.gov.mn
Ахлах аудитор Б.Жалбаа
Утас: 89330330, цахим хаяг: jalbaab@audit.gov.mn
Аудитор Д.Пүүжмаа
Утас: 99080797, Цахим хаяг: puujmaad@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу: Цахим хуудас www.open.audit.mn

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР.....	2
ХҮСНЭГТИЙН ТОВЬЁГ.....	2
АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ.....	3
БҮЛЭГ 1. УИХ-ЫН СОНГУУЛЬД УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫГ ХУУЛЬ ЖУРМЫН ДАГУУ ТӨЛӨВЛӨЖ ХУВААРИЛСАН БАЙНА...4-5	
БҮЛЭГ Б. УИХ-ЫН СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДОН УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛЖ, ӨР АВЛАГАГҮЙ АЖИЛЛАСАН БАЙНА.....	6-7
ДҮГНЭЛТ.....	8
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ.....	9

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ҮАГ	Үндэсний Аудитын Газар
УИХ	Улсын Их Хурал
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
МТБ	Мэдээлэл технологийн баг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл

ХҮСНЭГТИЙН ТОВЬЁГ

№	Тайлбар	Хуудасны дугаар
1	Улсын төсвөөс хуваарилсан төсөв	
2	Аймаг сумын сонгуулийн хороодод хуваарилсан төсөв	
3	Улсын бүртгэлийн ерөнхий газраас хуваарилсан төсөв	
4	Цагдаагийн ерөнхий газраас хуваарилсан төсөв	

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт арга зүй	
Аудит үндэслэл, бүрэн эрх	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3-т заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны 8 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/162 дугаар тушаалыг тус тус үндэслэн аудитыг хийж гүйцэтгэсэн. УИХ-ын 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулан аудитын тайланг Үндэсний аудитын газар болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн. Уг зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: • УИХ-ын сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх • УИХ-ын сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг зориулалтын дагуу арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэх
Аудитын зорилт	
Аудитын хамарсан хүрээ	Аудитад аймаг сумын сонгуулийн хороод, Улсын бүртгэлийн хэлтэс, аймгийн Цагдаагийн газрыг хамруулан зардлын гүйцэтгэлд аудитыг хийсэн.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг нийцлийн аудитын стандарт АДБОУС 100, 400,3000-4000, Монгол Улсын Төрийн аудитын “Нийцлийн аудитын зарчим”, MNS 6817-6:2020 “Нийцлийн аудит MNS 6817-8:2020 стандарт”, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ хийх, харьцуулах, тулган баталгаажуулах, түүвэрлэлт хийх зэрэг судалгааны арга зүйг ашигласан.
Аудитын багийн бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа, аудитын менежер Х.Болдбаатар нар хянан удирдаж, ахлах аудитор Б.Жалбаа, аудитор Д.Пүүжмаа нар 2024 оны 07 дугаар сарын 16-аас эхлэн 2024 оны 08 дугаар сарын 01-ний хооронд хийж гүйцэтгэлээ.
Хүндрэл бэрхшээл	Аудитыг гүйцэтгэх явцад баяр наадмын өдрүүд тохиож, холбогдох алба хаагчид амарсан зэрэг нь тайлбар тодруулга, нэмэлт мэдээлэл авахад хүндрэлтэй байлаа.

БҮЛЭГ 1. УИХ-ын сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль журмын дагуу төлөвлөж хуваарилсан байна.

УИХ-ын ээлжит сонгуулийн хүрээнд аймаг, сумын 25 сонгуулийн хороо, 112 хэсгийн хороо байгуулагдаж 1288 хүний бүрэлдэхүүнтэй ажиллажээ.

Сонгуулийн хорооны зардлын төсвийн төсөлд орон нутгаас санал аваагүй, төсвийг СЕХ-оос шууд хуваарилсан байна.

УИХ-ын ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс Аймгийн сонгуулийн хороонд 1,177.8 сая төгрөгийн 16 нэр төрлийн зардлыг хуваарилсан байна. Үүнд:

Хүснэгт 1. Улсын төсвөөс хуваарилсан төсөв

д/д	Зардлын нэр	/мян.төг/	
		Батлагдсан төсөв	
1	Маягт, хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	300.0	
2	Сонгуулийн хорооны гишүүдийн сургалт	18,274.4	
3	МТБ, даамлын сургалт	25,100.0	
4	Бичиг хэрэг	18,040.0	
5	Шуудан холбоо	21,400.0	
6	Унаа /тээвэр шатахуун/	98,098.0	
7	Санал авах байр бэлтгэх	34,720.0	
8	Сурталчилгаа	8,000.0	
9	Саналын хуудас, төхөөрөмж авах,хүргэх ачаа, томилолтын зардал	61,818.0	
10	МТБ-ийн гишүүний холбоо, унааны зардал	1,300.0	
11	Сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал, НДШ	705,320.0	
12	МТБ-ийн гишүүн, даамлын урамшуулал, НДШ	88,088.0	
13	Хоолны зардал	64,400.0	
14	Томилолт зардал	17,414.7	
15	Шуурхай багийн зардал	2,130.0	
16	Болзошгүй зардал	13,440.0	
ДҮН		1,177,843.1	

Сумын сонгуулийн хороо, хэсгийн хороодод төсөв хуваарилахдаа байршил, алслагдсан байдал, хэсгийн хороодын тоо, ажиллах бүрэлдэхүүний тоонд үндэслэн хуваарилалт хийсэн байна.

Хүснэгт 2. Аймаг сумын сонгуулийн хороодод хуваарилсан төсөв

д/д	Сонгуулийн хорооны нэр	/мян.төг/	
		Хуваарилсан төсөв	Ажиллах хүний тоо
1	Аймгийн сонгуулийн хороо	83,340.4	16
2	Алдархаан сумын сонгуулийн хороо	56,148.0	66
3	Асгат сумын сонгуулийн хороо	23,396.0	26
4	Баянтэс сумын сонгуулийн хороо	40,364.5	46
5	Баянхайрхан сумын сонгуулийн хороо	41,344.5	48
6	Дөрвөлжин сумын сонгуулийн хороо	49,746.0	58
7	Завханмандал сумын сонгуулийн хороо	41,262.5	48
8	Идэр сумын сонгуулийн хороо	40,881.0	48
9	Их-Уул сумын сонгуулийн хороо	50,180.0	56
10	Нөмрөг сумын сонгуулийн хороо	48,088.0	56
11	Отгон сумын сонгуулийн хороо	57,986.0	68
12	Сантмаргаз сумын сонгуулийн хороо	40,407.2	46
13	Сонгино сумын сонгуулийн хороо	48,462.5	56
14	Тосонцэнгэл сумын сонгуулийн хороо	66,551.5	78

**УИХ-ын ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс олгосон
санхүүжилтийн гүйцэтгэл**

15	Тэлмэн сумын сонгуулийн хороо	52,567.0	60
16	Тэс сумын сонгуулийн хороо	38,981.5	44
17	Түдэвтэй сумын сонгуулийн хороо	48,242.0	56
18	Ургамал сумын сонгуулийн хороо	33,224.0	38
19	Улиастай сумын сонгуулийн хороо	56,250.0	70
20	Цагаанчулуут сумын сонгуулийн хороо	40,847.5	48
21	Цагаанхайрхан сумын сонгуулийн хороо	39,430.0	46
22	Цэцэн-Уул сумын сонгуулийн хороо	41,590.0	48
23	Шилүүстэй сумын сонгуулийн хороо	41,250.5	48
24	Эрдэнэхайрхан сумын сонгуулийн хороо	48,218.5	56
25	Яруу сумын сонгуулийн хороо	49,084.0	58
ДҮН		1,177,843.1	1288

УИХ-ын ээлжит сонгууль зохион байгуулахтай холбоотой Улсын бүртгэлийн хэлтэст 105.1 сая төгрөгийг, аймгийн Цагдаагийн газарт 55.7 сая төгрөгийг улсын төсвөөс тус тус хуваарилахаар баталсан байна.

Хүснэгт 3. Улсын бүртгэлийн ерөнхий газраас хуваарилсан төсөв

		/мян.төг/
д/д	Зардлын нэр	Батлагдсан төсөв
1	Сонгогчдын нэрийн жагсаалт хэвлэх, хэсгийн хороодод хүргүүлэх зардал	6,485.3
2	Сургалт зохион байгуулах болон түүнтэй холбогдон гарах бусад зардал	20,404.0
3	Сонгогчийг бүртгэх, таних техник хэрэгслийг тээвэрлэх болон техник хэрэгслийн хэвийн ажиллагааг хангаж ажиллах шуурхай багийн зардал	8,436.0
4	Улсын бүртгэлийн байгууллагын ажилтан, итгэмжлэгдсэн ажилтны болон гэрээт ажилтны мөнгөн урамшуулал, хоол, унааны зардал	69,740.0
ДҮН		105,065.3

Сонгууль зохион байгуулахтай холбогдуулан улсын бүртгэлийн хэлтэс нь байгууллагын ажилтан 11, итгэмжлэгдсэн ажилтан 113, нийт 124 хүний бүрэлдэхүүнтэй ажиллахаар төлөвлөжээ.

Сонгууль зохион байгуулах зардлыг төлөвлөхдөө аймгийн Улсын бүртгэлийн хэлтсээс төсвийн төсөлд санал аваагүй, дээд шатны төсөв захирагчаас зардлыг шууд хуваарилсан байна.

Хүснэгт 4. Цагдаагийн ерөнхий газраас хуваарилсан төсөв

		/мян.төг/
д/д	Зардлын нэр	Баталсан төсөв
1	Тээвэр шатахуун	3,000.0
2	Шуудан холбоо, интернет	15,440.0
3	Хоол хүнс	37,224.0
ДҮН		55,664.0

Аймгийн Цагдаагийн алба хаагчид сонгуулийн үед санал хураалтын хамгаалалтад үүрэг гүйцэтгэсэн байна.

Дээд шатны төсөв захирагчаас хуваарилсан төсвийг зориулалтын дагуу зарцуулжээ.

БҮЛЭГ 2. УИХ-ын сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг зориулалтын дагуу зарцуулж, өр авлагагүй ажилласан байна.

Улсын төсвөөс олгосон санхүүжилтийн гүйцэтгэлийг аудитад хамрагдсан байгууллага тус бүрээр нь дүгнэлээ.

- **Аймгийн сонгуулийн хороо:**

УИХ-ын ээлжит сонгууль зохион байгуулахтай холбоотой Аймгийн сонгуулийн хороонд хуваарилсан 1,177.8 сая төгрөгийн 93 хувь буюу 1,094.5 сая төгрөгийг сумдын сонгуулийн хороод зарцуулжээ.

Улсын төсвөөс олгосон санхүүжилтийн 857.8 сая буюу 72.8 хувь нь сонгууль зохион байгуулахад ажилласан алба хаагчдын цалин, урамшуулал, хоолны мөнгө байна.

Улсын төсвөөс олгосон санхүүжилтийн сонгуулийн бичиг баримт, техник хэрэгсэл болон сурталчилгааны материалыг аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороо, санал авах байранд хүргэх, буцаан татах, сургалт, сурталчилгаа, унаа, албан томилолт, болзошгүй зардалд үүссэн 6.5 сая төгрөгийн хэмнэлтийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Аудитаар зарцуулалтыг зардлын эдийн засгийн ангиллын хүрээнд зориулалтын дагуу, арвилан хэмнэлттэй зарцуулсан байна.

Аймаг сумын сонгуулийн хороо, хэсгийн хороодын байр бэлтгэхтэй холбоотой худалдан авсан аж ахуйн материалыг холбогдох шатны ЗДТГ-т хүлээлгэн өгчээ.

Сонгууль зохион байгуулахтай холбогдуулан улсын төсвөөс олгосон санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулж, өр авлагагүй ажиллажээ.

- **Улсын бүртгэлийн хэлтэс**

Улсын бүртгэлийн ерөнхий газраас 105.1 сая төгрөгийн төсөв олгохоор хуваарилсан хэдий ч гүйцэтгэлээр 110.5 сая төгрөг олгогдож 5.4 сая төгрөг илүү байгаа нь сонгуулийн тоног төхөөрөмжийн сүлжээг шалгах зардлыг нэмэлтээр олгосонтой холбоотой байна.

УИХ-ын сонгууль зохион байгуулахтай холбогдон УБЕГ-аас хуваарилсан төсвийн зарцуулалтыг судлан үзэхэд итгэмжлэгдсэн ажилчдын цалинг 578,230 төгрөгөөр тооцон 113 хүнд олгохоор төсөв хуваарилсан ч бодит байдалд 660,000 төгрөгөөр тооцон 88 хүнд олгож, улсын бүртгэгч нарт цалин олгоогүй байна.

Энэ нь улсын төсвөөс олгосон санхүүжилт өмнөх сонгуулийн жилд олгосон санхүүжилтээс буурч батлагдсантай холбоотой гэсэн тайлбарыг холбогдох албан тушаалтнууд өглөө.

Дүгнэлт:

1. Сонгуулийн зардлын төсвийн төсөлд орон нутгийн байгууллагуудаас санал авалгүй дээд шатны байгууллагаас шууд хуваарилсан байна.
2. Улсын төсвөөс олгосон санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулж, өр авлагагүй ажилласан байна.
3. НББ-ийн тухай хуульд нийцүүлэн анхан шатны баримтыг бүрдүүлэн, архивын нэгж үүсгэсэн байна.
4. Сонгуулийн зардлын хэмнэлтийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Д.БАТ-УНДРАА



**ЗАВХАН АЙМГИЙН
СОНГУУЛИЙН ХОРОО**

81090 Улиастай, Завхан аймаг

Утас: 7046-2454

И-мэйл: zavkhanelection@gmail.com

2024.07.30 № 32

танай _____-ны № _____ т

**ЗАВХАН АЙМГИЙН ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн зардлын гүйцэтгэлд хийсэн аудитын дүгнэлттэй танилцав.

Аудитын дүгнэлттэй холбоотой ямар нэгэн саналгүй болно.

ДАРГА



Т.РЭНЧИНВАНЖИЛ